

ЗҮҮН ХОЙД АЗИ ДАХЬ ЭРЧИМ ХҮЧНИЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Д.Отгончимэг*, Б.Санжмятав**

Аливаа улс орны үндэсний аюулгүй байдлын баталгааг хангах, олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвараа сайжруулах асуудал нь түлш шатахууны тогтвортой, найдвартай эх үүсвэртэй байхаас ихээхэн шалтгаалдаг. Сүүлийн жилүүдэд дэлхийн зах зээл дээр нефть, нефтийн бүтээгдэхүүний хэрэглээ өсч, үнэ өртөг нь нэмэгдэх хандлагатай болсон нь тухайн бүтээгдэхүүнийг импортлогч орнуудад хүндээр тусч, ялангуяа Азийн орнууд бусдаас илүү хэлмэгдэх боллоо. Тухайлбал 2001-2003 онд Балба, Пакистан ба Энэтхэг нь өөрийн экспортын орлогынхоо 20-35 хувийг, Монгол 22 хувийг нефть, нефтийн бүтээгдэхүүн импортоор худалдан авахад зарцуулжээ.¹

Орчин үед эрчим хүчний эх үүсвэрийг импортлогч Хойд Америк, Европ, Ази гэсэн 3 үндсэн том зах зээл байгаа бөгөөд дэлхийн нефтийн импортод Зүүн хойд Ази 33.1 хувь, Хойд Америк 29.0 хувь, Европ 8.0 хувь эзэлж байна. Цаашид Азийн хэрэгцээ илүү хурдацтай өсөх төлөвтэй, үүнийг Японы эрчим хүчний эдийн засгийн институтээс 2005 онд хийсэн судалгаа нотолж байна.²

Эрчим хүчний хэрэглээ, тэрбум тн

Орон / он	2002	2010	2020	2030
АНУ, Канад	2.5	2.8	3.1	3.3
ЗХА:Хятад	2.0	2.4	3	3.5
Япон, Солонгос	0.7	0.8	0.9	1.0
Энэтхэг	0.5	0.6	0.7	1.0
Зүүн Ази	0.6	0.7	1.2	1.4
ЕХ	1.7	1.8	1.9	2.0

Өнөөдөр Азийн орнуудаас 371 сая хүн амтай 6 орон нефть, нефтийн бүтээгдэхүүнийг экспортлогч байхад хүн амын 90 орчим хувь буюу 2.948 тэрбум хүн амтай 17 орон нь тэдгээрийг импортлогч юм.³ Нефть, нефтийн бүтээгдэхүүн

* МУИС-ийн ОУХС-ийн дэд профессор, доктор (Ph.D)

** магистр, ОУХ-ны эдийн засагч

¹ WTO, World trade report 2005, p 13.

² Kensuke Kanekiyo, Managing Director of the Institute of Energy economics, Japan, Energy outlook of NEA and Regional Energy Partnership, SOM on Energy Cooperation in NEA, 17-18 November 2005 Ulaanbaatar, Mongolia

³ WTO, World trade report 2005, p 15.

хамгийн ихээр импортлогч орон нь Хятад, Япон, БНСУ, Энэтхэг улс юм. Харин хэрэглээний хувьд авч үзвэл Япон дэлхийд 2 дугаар байр, Хятад 3 дугаар байр, БНСУ 6 дугаар байрыг эзэлж байна. Судлаачдын үзэж байгаагаар, 2020 он хүртэлх хугацаанд дэлхийн эрчим хүчний хэрэглээ жилд дунджаар 2.2 хувиар өснө гэж үзвэл Хятадад 4.7 хувь, БНСУ-д 2.8 хувиар тус тус өсөх төлөвтэй байна.

Зүүн хойд Ази нь эрчим хүчний эх үүсвэрийн хувьд гаднаас хамаарах байдлаараа хамгийн дээгүүр ордог. Гэхдээ орон тус бүрийн хувьд энэ нь харилцан адилгүй. Тухайлбал Хятад улс дэлхийн эрчим хүчний эх үүсвэрийн томоохон импортлогч боловч дотоодын хэрэгцээнийхээ 90 хувийг өөрийн дотоод эх үүсвэрээс хангадаг байхад, Монгол улс нефтийн гаралтай бүтээгдэхүүний хэрэгцээгээ үндсэндээ бүрэн гаднаас авч хангадаг, Япон, БНСУ нь өөрийн хэрэгцээт байгалийн шатдаг хийний 79 хувийг, нефтийн 74 хувийг, нүүрсний 13 хувийг тус тус импортоор авдаг байна.⁴

Азийн орнуудын нефть, нефтийн бүтээгдэхүүнийг нийлүүлэгч гол түнш нь Ойрхи Дорнод юм. Азийн нефтийн импортод Ойрхи Дорнодын эзлэх хувь хэмжээ нь 2004 оны байдлаар Японы хувьд 88.9 хувь, БНСУ-ын хувьд 78.1 хувь, Хятадын хувьд 45.5 хувь тус тус байжээ. Эрчим хүчний эх үүсвэрийг импортлогч орнууд нэг бүс нутгаас хараат байдалтай байгаа нь эдийн засгийн аюулгүй байдал, үндэсний өрсөлдөх чадвараа сайжруулах үүднээс олон нийлүүлэгчтэй болох хүсэл эрмэлзлэлээ биелүүлэх арга замыг сүвэгчлэн олох нэн тулгамдсан асуудалтай тулгараад байна.

Өөр нэг асуудал бол эрчим хүчний эх үүсвэрийн оновчтой бүтцийг бүрдүүлэх асуудал юм. Азийн эрчим хүчний хэрэглээнд нүүрс 53.1 хувь, нефть 31.1 хувь, цөмийн эрчим хүч 4.9 хувь, байгалийн шатдаг хий 6.1 хувь, усны эрчим хүч 4.6 хувь тус тус эзэлж байна. Эрчим хүчний ихэнх хэсгийг нүүрснээс гарган авч байгаагийн улмаас Азийн эрчим хүчний систем нь үр ашиг багатай, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлж байна. ЗХА-д эдийн засгийн өсөлт хурдацтай явагдахын хирээр эрчим хүчний хэрэглээ, юуны өмнө байгалийн шатдаг хийн импорт өндөр хурдацтай өсөх хандлагатай байна. Тухайлбал 2020 он гэхэд

⁴ Kensuke Kanekiyo, *Managing Director of the Institute of Energy economics, japan, Energy outlook of NEA and Regional Energy Partnership, SOM on Energy Cooperation in NEA, 17-18 November 2005 Ulaanbaatar, Mongolia, p 3*

Хятадын байгалийн шатдаг хийн импорт 2 дахин нэмэгдэнэ гэсэн тооцоо байна. Иймээс ЗХА-ийн орнуудын хувьд эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, эх үүсвэрийн олон нийлүүлэгчтэй болох, нийлүүлэлтийг найдвартай болгох, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах зэрэг асуудал чухлаар тавигдаж байгаа бөгөөд ийм боломж ч байна. Энэ нь юуны түрүүнд бүс нутгийн дотоод нөөц бололцоог дээд зэргээр ашиглах, хамтын ажиллагааг өрнүүлэх хэрэгцээ шаардлагатай нягт холбоотой.

ЗХА-д орших ОХУ-ын Сибирийн бүс нутаг нь нефть, байгалийн шатдаг хийн асар их нөөцтэй болохоос гадна ОХУ нь өнөөдөр ч нефтийн үйлдвэрлэлээрээ дэлхийд II-т ордог. Сибирийн орд газрын байгалийн хийн нөөц нь 6000 тэрбум м³, Сахалины хормойн нөөц нь 1000 тэрбум м³ байна. ОХУ-ын нутагт дэлхийн нүүрсний нөөцийн 30 хувь эзэмшдэг, түүний 53 хувь нь Сибирьт байдаг тухай судалгаа байна. ОХУ нь 2000 онд экспортод 38 сая т нүүрс экспортолсны 9.7 сая тонныг Япон, 3.0 сая тонныг БНСУ авчээ. ОХУ нь ЗХА-д жил тутам 100-130 тэрбум м³ байгалийн хий, 60-70 сая т нефть, нефтийн бүтээгдэхүүн нийлүүлэх бололцоотой гэж судлаачид үзэж байна.

Дэлхийн нефтийн үйлдвэрлэл 2004 оны байдлаар, улс орнуудаар ⁵

№	Нефть олборлогч орнууд	Үйлдвэрлэл / сая баррель/
1.	Саудын Арави	10.58
2.	ОХУ	9.29
3.	АНУ	7.24
4.	Иран	4.08
5.	Мексик	3.82
6.	Хятад	3.49
7.	Казахстан	3.19
8.	Канад	3.09
9.	ОПЕК-ийн гишүүн орнууд	32.93
	Дэлхийн нийт олборлолт	80.25

Ийнхүү ЗХА-ийн орнууд нь эрчим хүчнийхээ эх үүсвэрийг газар зүйн хувьд хамгийн ойроос буюу ОХУ-аас авах бололцоо байгаа бөгөөд энэ нь ОХУ болон ЗХА-ийн орнуудын нэгдсэн эрх ашигт бүрэн нийцэж байгаа билээ. ЗХА-ийн орнууд эрчимтэй хөгжиж, 2020 он гэхэд нефть, байгалийн шатдаг хийн дэлхийн хамгийн том зах зээл болох төлөвтэй бол ОХУ зүүн бүсээ хөгжүүлэх,

⁵ Мөн тэнд х 7

нефть, байгалийн шатдаг хийн зах зээлээ өргөжүүлэх сонирхолтой. Иймд хоёр талын сонирхол, эрх ашигт нийцсэн хамтын ажиллагааг бодитойгоор хэрэгжүүлэхэд л асуудал оршиж байна. ОХУ нь Сибирийн эрчим хүчний эх булгийн нөөц тогтоох эрэл хайгуулын ажлаа үргэлжлүүлэн гүйцэтгэх, дэд бүтцээ хөгжүүлэхийн тулд санхүүгийн хомсдолыг шийдвэрлэх, орчин үеийн машин техник, технологиор хангагдсан байх шаардлагатай тулгараад байна. Тэгвэл Япон, Солонгос нь Сибирийн нөөц баялгийг ашиглахад эрчим хүч хэмнэх техник технологи, “know-how” нийлүүлэх боломжтой бөгөөд шаардлагатай бол Хятад, БНАСАУ-ын хямд ажиллах хүч ч байна.

ОХУ-ын Сибирээс ЗХА-д эрчим хүчний эх үүсвэрийг нийлүүлэх үндсэн байрлал болох Эрхүү мужаас бүс нутгийн үндсэн хэрэглэгчид 2000 км-ийн тойрогт багтаж байгаа нь харьцангуйгаар хол биш бөгөөд санхүү, эдийн засгийн талаас нь ч ашигтай байх бүрэн үндэслэлтэй. Мөн ЗХА нь өнөөдөр эрчим хүчний эх булагт нүүрсийг өргөнөөр хэрэглэж байгаагийн нэлээд хэсгийг нефть, шатдаг хийгээр сольж хүрээлэн буй орчинд учруулж буй ихээхэн хор хөнөөлийг багасгах боломжтой болно.

ОХУ-ын Засгийн газар дээрх байдлуудыг харгалзан 2004 онд Сибирийн эрчим хүчний эх булгуудыг ашиглах, улмаар ЗХА-ийн орнуудад экспортлох, үүний тулд зүүн тийш дамжуулах хойлойг барьж байгуулах шийдвэр гаргасан нь энэ салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлоход зарчмын чухал ач холбогдолтой юм. Судлаачдын үзэж байгаагаар одоогийн байдлаар ОХУ-аас ЗХА-ийн орнуудад экспортлох нефть, байгалийн шатдаг хийн хэмжээ нь 1.4 тэрбум ам.доллар бөгөөд 2020 он гэхэд 44 тэрбум ам. доллар болтол өсгөх бололцоо байна. Ийнхүү ЗХА-д эрчим хүчний эх булгийн худалдаа эрс нэмэгдэх нь бүс нутгийн эдийн засгийн хөгжилд үлэмж түлхэц өгч аюулгүй байдлыг бэхжүүлэх, үйлдвэрлэл, худалдаагаар дамжин ард түмний амьдралын түвшинг дээшлүүлэх шинэ өргөн боломж нээгдэх болно.

ЗХА-ийн орнууд ОХУ-ын эрчим хүчний эх булгыг хамтран ашиглахдаа юуны өмнө нефтийн салбарыг түлхүү хөгжүүлж үйлдвэрлэлийг нь нэмэгдүүлэх, нефть дамжуулах хоолойг барих, дараагийн шатанд байгалийн хийг ашиглах бодлогыг баримталж байна. Харин үүнийг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцлийг бүрдүүлэхийн тулд бүсийн эрчим хүчний худалдааны төвийг зохистой газар

(Владивостокийг сонгосон) байгуулах, мөн эрчим хүчний эх булгийг хадгалах агуулах сав барьж байгуулах, тээвэрлэлтийн бололцоог бүрдүүлэх, хөрөнгө оруулах эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх шаардлага гарч байна.

ЗХА-ийн орнууд эрчим хүчний салбарт бодитой хамтын ажиллагааг хөгжүүлэх бүтэц зохион байгуулалт, эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр бодитой алхмуудыг хийгээд байна. Тухайлбал 2001 оны 10 дугаар сард ОХУ-ын Хабаровскт НҮБ-ын АНДЭЗНК-ийн дэмжлэгтэйгээр бүс нутгийн орнуудын эрчим хүчний салбарын экспертүүдийн уулзалтыг зохион байгуулсан билээ. Уг уулзалтаар бүс нутгийн эрчим хүчний хангамжийн асуудлыг авч ярилцсан ба уг асуудал нь стратегийн ач холбогдолтой, ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт, техникийн зохицуулалт шаардах тул түүнийг нарийвчлан судлах, эрчим хүчний салбарын хамтын ажиллагааг зохицуулах шаардлагатай байгааг тодорхойлон гаргажээ. ЗХА-ийн орнуудын эрчим хүчний салбарын ахлах албан тушаалтнуудын 2003 оны 4 дүгээр сард Владивостокт болсон уулзалтаас хамтын ажиллагааны асуудлыг эрхлэх засгийн газар хоорондын зөвлөлдөх механизмыг бий болгох талаар зарчмын хувьд тохиролцон, үйл ажиллагааных нь журам (Proposed Mechanism for Inter-Governmental Consultation on Energy Cooperation in North-East Asia)-ын төслийг боловсруулсан байна. 2004 оны 9 дүгээр сард Бангкок болсон ЗХА-ийн орнуудын анхны Зөвлөлдөх уулзалтаас бүс нутагт эрчим хүчний салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх асар их бололцоо байгааг дахин нотолж, энэ чиглэлээр зорилготой бөгөөд байнгын үйл ажиллагаа явуулахаар шийдвэрлэж, Зөвлөлдөх механизм дүрмийг батлан судалгааны ажлын хэсгийг (Task Force) байгуулсан. Мөн зөвлөлдөх механизмын нарийн бичгийн дарга нарын газрын үүргийг 3 жилийн хугацаанд НҮБ-ын АНДЭЗНК-оор гүйцэтгүүлэх талаар тохиролцжээ. Дүрэмд зөвлөлдөх механизмын үндсэн зорилтуудыг:

- ЗХА-д эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлснээр бусад бүс нутгаас хамаарах хамаарлыг багасгах;
- Эрчим хүчний хангамж, хэрэглээний үр ашиг, хэмнэлтийг дээшлүүлэх;
- Эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээний хүрээлэн буй орчинд нөлөөлөх муу нөлөөг багасгах гэж тодорхойлжээ. Энэ нь хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлийг мөн тодорхойлж байна.

Мөн улс орнууд өөрийн эрчим хүчний эх булгаа өөрөө мэдэж зарцуулах эрх, дотоодын эрхтэй холбоотой эрх зүйг шинэчлэхийг шаардахгүй байх, улс орнуудыг ялгаварлан гадуурхахгүй байх, эрчим хүчний бүтээгдэхүүнийг өөрийн нутгаар саадгүйгээр дамжин тээвэрлүүлэх, хөрөнгө оруулалтыг хамгаалах, бодлогыг ил тод бөгөөд урьдчилан харах боломжтой байлгах зэрэг харилцааны үндсэн зарчмуудыг тусгаснаас гадна манай орны хувьд зарчмын ач холбогдолтой заалт тусгагдсан юм. Тухайлбал бүс нутгийн орнуудын хөгжлийн түвшингийн ялгааг харгалзан үзэж БНАСАУ, Монголд дэмжлэг үзүүлж байх тухай заалт оруулжээ. Зөвлөлдөх механизм нь гишүүн орнуудын төлөөлөгчдөөс бүрдэх бөгөөд аливаа асуудлаар шийдвэрийг нийтийн тохиролцоогоор гаргана.

Зөвлөлдөх механизмын ажлын хэсгийн II уулзалт 2005 оны 4 дүгээр сард Улаанбаатар хотод болсон. Уулзалт судалгааны бүлгээс хийсэн ажлын үр дүнг авч хэлэлцээд ЗХА-д эрчим хүчний хамтын ажиллагааг хөгжүүлэх өргөн бололцоо байгааг дахин нотлохын хамт дээрх хамтын ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй хамтын ажиллагааны байнгын механизмыг бий болгох нь зүйтэй гэж үзэж, түүнийг байгуулан ажиллуулах талаар шийдвэр гаргасан юм. ЗХА-ийн орнуудын Эрчим хүчний хамтын ажиллагааны механизмын хүрээнд мөн нэлээд хэдэн ажлыг хэсэг байгуулан ажиллуулах, тэдгээрийн дотроос Эрчим хүчний төлөвлөлт, бодлогын асуудлыг хариуцсан Ажлын хэсгийг тэргүүлэх ач холбогдолтой байлгах, түүнийг даруй байгуулан ажилд нь оруулах, энэхүү ажлын хэсэг нь шаардлагатай бусад Ажлын хэсгийг байгуулах саналаа Ахлах албан тушаалтнуудын Хороонд танилцуулах боломжтой байх талаарх зөвлөмжийг хамтын ажиллагааны байнгын механизм болох Ахлах албан тушаалтнуудын Хороонд өгсөн болно. Мөн эрчим хүчний хамтын ажиллагааны механизм болох Ахлах албан тушаалтнуудын Хороо (ААТХ буюу Хороо), Ажлын хэсэг (АХ)-үүд, Нарийн бичгийн дарга нарын газар (НБДНГ)-ын үйл ажиллагааны хүрээг тодорхойлсон байна⁶.

Ийнхүү ЗХА-ийн орнуудын эрчим хүчний хамтын ажиллагаа эхний үедээ экспертүүдийн хэмжээнд зөвлөлдөх үйл ажиллагаагаар хязгаарлагдаж байсан бол орчин үед байнгын шинж чанар бүхий механизм төлөвшин тогтоод байна.

⁶ *Conclusions and Recommendations*

Inter-Governmental Meeting on Energy Cooperation in North-East Asia: Task Force on Energy, 13-14 April 2005, Ulaanbaatar, Mongolia. para. 2, p 1.

Улаанбаатарын уулзалтаас ЗХА-ийн орнуудын эрчим хүчний салбар дахь хамтын ажиллагааг юуны өмнө 6 салбарт хөгжүүлж, дараах зорилгод хүрэхийг зөвлөмж болголоо. Үүнд:

1. *Эрчим хүчний төлөвлөлт, бодлогын салбарын* хамтын ажиллагааны зорилтыг 2020 он гэхэд гишүүн орнуудын хүрээнд эрчим хүчний аюулгүй байдлыг хангах бодлого, хууль эрх зүйн орчинг ойртуулан уялдуулах, эрчим хүчний аюулгүй байдлын зорилтыг үндэсний тогтвортой хөгжлийн стратеги, төлөвлөлтөд тусган, үе шаттайгаар шийдвэрлэх гэж тодорхойлжээ. Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд гишүүн орнууд ЗХА-ийн орнуудын хил дамнасан эрчим хүчний хамтын ажиллагааны талаарх бодлогоо тодорхойлох, эрх зүйн орчинг ойртуулах арга хэмжээний төлөвлөгөө гаргах, ЗХА-ийн эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах судалгаа, үндэслэлийг боловсруулах, эрчим хүчний үнэ тогтоох механизмыг өөрчлөн шинэчлэх, эрчим хүчний салбарт хэрэгжүүлэх төслүүд, хөтөлбөрийг боловсруулах талаар хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх;
2. *Хөрөнгө оруулалтын бодлогын салбарын* хамтын ажиллагааны зорилт нь 2020 он гэхэд ЗХА-д эрчим хүчний аюулгүй байдлыг сайжруулахын тулд гишүүн орнууд эрчим хүчний салбарын хамтын ажиллагааг тогтвортой хөгжлийг хангах байдлаар, олон улсын, түүний дотор Дэлхийн худалдааны байгууллагын стандарт, журмын дагуу өргөжүүлэн хөгжүүлэхэд оршино. Гишүүн орнууд дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд өөрийн оронд мөрдөж байгаа хууль эрх зүйн орчин нь олон улсын стандарт, журамд хэрхэн нийцэж байгаад үнэлэлт өгч, улмаар тэдгээрийг ДХБ-ын холбогдох хэлэлцээрүүд, мөн түүнчлэн ДХБ-ын хүрээнд эрчим хүчний салбарт бараа, үйлчилгээний худалдааны талаар хийж байгаа хэлэлцээний үзэл санаанд нийцүүлэх арга хэмжээг авах, ЗХА-д эрчим хүчний хамтын ажиллагааг хөгжүүлэх эрх зүйн нэгдсэн орчинг бүрдүүлэх, эрчим хүчний салбар дахь худалдааны саад тотгорыг арилгах, хөрөнгө оруулалтыг дэмжих, дээрх чиглэлүүдээр хамтын ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх;

3. Эрчим хүчийг үйлдвэрлэгч станцуудыг хөгжүүлэн хооронд нь холбох салбарт гишүүн орнууд нь эрчим хүчний салбарт олон талт хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, эрчим хүчний худалдааг нэмэгдүүлэх зорилтыг тавьж байна. Гишүүн орнууд нь дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд эрчим хүчний эх булгийг ашиглах талаарх судалгаа, тэдгээрийн техник-эдийн засгийн үндэслэлүүдийг гаргахаас гадна эрчим хүч, түүний эх үүсвэрийг дамжуулах талаар гэрээ, хэлэлцээр байгуулах, хамтын ажиллагааны бодлогын дунд, урт хугацааны баримт бичгийг боловсруулан тохиролцох, түүний үндсэн дээр хамтын ажиллагааны хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх, тэдгээрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг олон улсын хамтын ажиллагааны системээс олох, хэрэгтэй мэдээлэл, туршлагаа солилцох, боловсон хүчин бэлтгэх талаар хамтран ажиллах;

4. Эрчим хүч, түүний эх булгийн худалдааг нэмэгдүүлж, тэдгээрийг хил дамжуулан тээвэрлэх талаар тохиролцоонд хүрэх. Гишүүн орнууд үүний тулд ЗХА-д эрчим хүчний эх булгийн худалдааны нөөц, бололцооны талаар судалгаа явуулах, түүнтэй уялдуулан эрчим хүчний үндэсний бодлого, эрх зүйн орчинг тодорхойлох, эрчим хүчний эх булгийг тээвэрлэх дэд бүтэц, эрх зүйн орчинг бүрдүүлэх, худалдааны саад тотгорыг арилгах талаар хамтран ажиллах;

5. ЗХА-д эрчим хүчний салбарын үр ашгийг сайжруулахын тулд бүс нутгийн хэмжээнд хамтран ажиллах чиглэлийг тодорхойлох, эрх зүйн орчинг сайжруулах, дэлхийн цаг агаарын өөрчлөлтөд муугаар нөлөөлөхгүй чиглэлийн хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлэх, эрчим хүчний үр ашгийг сайжруулах, тэргүүний технологийн чиглэлээр мэдээлэл солилцох ажлыг өргөжүүлэх, боловсон хүчин бэлтгэх талаарх хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх;

6. Сэргээгдэх эрчим хүч, түүний дотор усны эрчим хүчийг ашиглах, хог хаягдлыг эрчим хүч гаргахад ашиглах чиглэлээр баримтлах үндэсний бодлого, түүний дотор сэргээгдэх эрчим хүчний үнэ тогтоох, хөрөнгө оруулах бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх, сэргээгдэх эрчим хүчийг ашиглахад зориулан санхүүгийн эх булгийг олох, үүнд хувийн хэвшлийг

өргөнөөр татан оролцуулах нөхцлийг бүрдүүлэх, энэ талаарх туршлага, мэдээллийг гишүүн орнууд солилцох, технологи дамжуулах явдлыг хөхүүлэн дэмжих, хог хаягдлыг дахин ашиглахыг засгийн газраас бодлогоор дэмжих, ЗХА-ийн орнуудын сэргээгдэх эрчим хүчийг ашиглах стратегийг боловсруулах.

Эрчим хүчний салбар дахь хамтын ажиллагааг хөгжүүлэх энэхүү зөвлөмж нь Монгол орны хувьд ЗХА-ийн орнуудтай хамтын ажиллагааг өрнүүлэх чиглэлийг тодорхойлж байгаагаас гадна манай орны эрчим хүчний салбарыг хөгжүүлэх бодлогын хүрээг тодорхойлоход чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

ЗХА-д эрчим хүчний салбарт хамтран ажиллах механизм болох гишүүн орнуудын Ахлах албан тушаалтнуудын Хорооны анхны хуралдаан 2005 оны 11 дүгээр сарын 16-17-нд Улаанбаатар хотноо болж өнгөрөв. Хуралдаанаас 2020 он хүртэл ЗХА-д эрчим хүчний салбарт хамтран ажиллах чиглэлийг нийтийн тохиролцоогоор тодорхойлон гаргасан⁷, Хорооны үйл ажиллагааны зарчмуудыг илүү тодорхой болгож өгсөн, Ажлын хэсгүүдийн үйл ажиллагааны журам, Улаанбаатарын тохиролцооны баримт бичиг, 2006-2007 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан нь ЗХА-ийн эрчим хүчний хамтын ажиллагааны механизмыг бүтэц, зохион байгуулалтын хувьд бэхжүүлсэн төдийгүй ойрын хугацааны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталснаараа чухал ач холбогдолтой боллоо.

АСЕАН зэрэг орны хамтын ажиллагааны механизм нь нэгэнт тогтсон тул дээрээс шийдвэр гаргаж, түүнийг нь олон талт хамтын ажиллагааны механизмаар дамжуулан хэрэгжүүлдэг бол ЗХА-ийн эрчим хүчний хамтын ажиллагааны механизм нь доороос дээш чиглэсэн, өөрөөр хэлбэл доороос гарсан саналтай гишүүн орнуудын удирдлага танилцан шийдвэр гаргадгаараа онцлог юм. Талуудын үзэж байгаагаар ЗХА-ийн эрчим хүчний хамтын ажиллагааны механизмд юуны өмнө БНХАУ, БНАСАУ, БНСУ, Япон, Монгол, ОХУ хамрагдана. Бусад орон, ОУБ-ууд нь сонирхлоо илэрхийлж, бүс нутгийн эрчим хүчний хамтын ажиллагаанд эрх тэгш гишүүн, ажиглагчаар оролцох, техникийн буюу санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх бололцоотой байхаар зохицуулсан

⁷ Collaborative mechanism on Energy cooperation in NEA, adopted by Senior Officials Committee on Energy Cooperation in NEA, First Session, 16-17 November 2005, Ulaanbaatar, Mongolia

байна. Үүнээс үзэхэд Монгол улсын хувьд ЗХА-ийн эрчим хүчний салбарын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох өргөн боломж нээгдэж байна.

ЗХА-ийн эрчим хүчний хамтын ажиллагааны механизм нь бүс нутгийн бүх орныг нэгтгэсэн хамтын ажиллагааны цорын ганц хүрээ болж тухайн бүс нутгийн эдийн засгийн интеграцчиллын эхлэлийг тавьж байна.

Эрдэмтэн судлаачид болон ОУБ-ын төлөөлөгчдийн зүгээс ЗХА-ийн эрчим хүчний хамтын ажиллагааг богино хугацаанд засгийн газар хоорондын хамтын ажиллагааны механизм (ААТХ)-ыг тогтоож хэвшүүлэх, итгэлцлийг бэхжүүлэх, бизнесийн төлөөлөгчдийн хооронд хэлхээ холбоо тогтоохыг дэмжих, мэдээлэл солилцох, эрчим хүчний эх булгийн талаар хамтарсан судалгаа, эрэл хайгуулын ажил хийх, улс хоорондын эрчим хүчний шугамыг хооронд нь холбох, нефтийн нөөцийн агуулахууд барих, боловсон хүчин бэлтгэх салбарт хамтран ажиллах, урт хугацаанд эрчим хүчний салбарын олон талт хамтын ажиллагааны болон эрчим хүчний салбарын бодлогын асуудлаар зохицуулалт хариуцсан тусгай бүтцийн хэмжээнд хамтран ажиллах, бүс нутгийн хэмжээний хөрөнгө оруулалтын тусгай агентлаг байгуулах зэрэг санал дэвшүүлж байна. АХБ-ны төлөөлөгчөөс хэлсэн үгэндээ, АХБ-ыг байгуулах болсон үндсэн зорилтуудын нэг нь бүс нутгийн хамтын ажиллагааг дэмжих явдал болохыг дурдаад, ЗХА-ийн орнуудтай эрчим хүчний салбарт хамтран ажиллахад бэлэн байгаагаа тэмдэглэж байв.

ОХУ нь өөрийн нутгийн зүүн хэсгийг хөгжүүлэхэд анхаарч, энд байгаа эрчим хүчний эх булгийг илүү ашиглах, зүүн тийш нь нефть, байгалийн хий дамжуулах хоолойг барих зарчмын шийдвэрийг гаргасан боловч хэрэгжүүлэх ажил удаашралтай байгаа билээ. ОХУ нь БНСАУ, БНХАУ руу цахилгаан дамжуулах шугам барихаар төлөвлөж, хөрөнгийн зарим хэсгийг шийдэж байгаа юм байна. ОХУ-ын транснефть компани Хятадын түншүүдтэйгээ нефть, байгалийн хий дамжуулах хоолой барих талаар урьдчилсан хэлэлцээ хийж байгаа боловч одоогоор засгийн газрын хэмжээнд шийдвэр гараагүй⁸.

ЗХА-ийн эрчим хүчний хамтын ажиллагаа нь юуны өмнө нефтийн салбарт ОХУ-ын Зүүн сибирийн эрчим хүчний орд газрыг эзэмших, нефть, зүүн

⁸ B.Saneev, Deputy Director, Energy Systems Institute, SB RAS, Irkutsk, Russia, Energy Cooperation and Trade in Energy resources of Russia and NEA Countries: Prerequisites, potential directions and benefits, Senior Officials Committee on Energy Cooperation in NEA, First Session, 16-17 November 2005, Ulaanbaatar, Mongolia

тийш хоолойг, тухайлбал ОХУ-ын Эрхүү муж-Владивосток, Хятадын Дакинг (Daqing) чиглэлээр барих, хилийн орчимд хамтарсан агуулахуудыг байгуулах, хамтарсан нефть боловсруулах үйлдвэрүүдийг барих, байгалийн хийн салбарт Эрхүү, Якут, Сахалины орд газруудыг эзэмших, Орос-Хятад-БНСУ болон Орос-БНАСАУ-БНСУ гэсэн дамжуулах хоолойг барьж ашиглалтад оруулах, цахилгаан дамжуулах салбарт ЗХА-ийн цахилгаан дамжуулах шугамуудыг ОХУ-ын Усан цахилгаан станцуудтай холбох, ОХУ-Хятад (ОХУ-ын Эрхүү муж-Хятадын Харбин, Тьянжин), ОХУ-Япон (Сахалин-Вахрушево-Хонсу арал), ОХУ-БНАСАУ-БНСУ-ын цахилгаан дамжуулах хоолойг барьж ашиглалтад оруулах, мөн ОХУ-ын зүүн хэсэгт ЗХА-ийн эрчим хүчний эх үүсвэрийн худалдааны төвийг байгуулах чиглэлээр хөгжих төлөвтэй байна.

ЗХА-ийн эрчим хүчний хамтын ажиллагааны хүрээнд дээр дурдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх нь бүс нутгийн эрчим хүчний хангамж, аюулгүй байдлыг сайжруулахад мэдэгдэхүйц нөлөө үзүүлж, бүс нутгийн олон улсын хэмжээнд өрсөлдөх чадварыг нэлээд хэмжээгээр дээшлүүлэхээс гадна бүс нутгийн орнуудын, юуны өмнө ОХУ, Хятадын зүүн хэсгийн эдийн засгийг хөгжүүлэх, ард түмний амьдралын түвшинг сайжруулахад чухал нөлөөтэй.

Эрчим хүчний эх үүсвэрийг тээвэрлэхэд хоолойн тээвэр нь хамгийн зардал багатай, найдвартай билээ. Гэтэл харамсалтай нь бүс нутгийн эрчим хүчний эх үүсвэрийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх урьдчилсан төлөвлөгөөнд Монголын нутгаар дайрах нэг ч хоолой тусгагдаагүй байна. Харин ОХУ-аас Хятад руу татах цахилгаан дамжуулах нэг шугам Монголын нутагт баригдах магадлал байна. Иймд манай талаас бүс нутгийн эрчим хүчний олон талын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох талаар анхаарч, санаачилгатай ажиллах зайлшгүй шаардлага байна. Монгол улсын өмнөд хэсэгт коксждог нүүрсний томоохон орд байгаа ба мөн зүүн бүсэд ч нефтийн илрэлүүд байгааг зөв эргэлтэд оруулах хэрэгтэй юм. Бүс нутгийн эрчим хүчний эх булгийг тээвэрлэх зарим хоолойг Монголын нутгаар дайруулан тавибал эдийн засгийн хувьд хамгийн үр ашигтай болохыг бодолцон энэ талаар холбогдох орнуудтай тохиролцох, шаардлагатай таатай нөхцлийг бүрдүүлэх, баталгаа гаргаж өгөх талаар санаачлага хэрэгтэй байна.